



# “СИНГАПУРЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ” СУДАЛГААНЫ ТАЙЛАН

2015 он

Нийслэлийн Аялал Жуулчлалын Газрын захиалгаар бэлтгэв.

# Агуулга

1

1.

ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2.

ВИЗИЙН НӨХЦӨЛ

3.

ЖУУЛЧДЫН ОНЦЛОГ

4.

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СОНГОЛТ

5.

ЗОРИХ ГАЗРУУД

6.

МӨНГӨНИЙ ЗАРЦУУЛАЛТ

7.

МАРКЕТИНГИЙН СУВГУУД

8.

ӨРСӨЛДӨГЧИД

9.

ЗӨВЛӨМЖ

# ӨМНӨХ ҮГ

2

- **Сингапур** (Хятад:新加坡; Малай: Singapura; Тамил:சிங்கப்பூர்) нь Малайн хойгийн өмнөд хошуунд орших арлаас тогтох зүүн өмнөд Азийн хот улс юм. Экваторын хойд зүгт 137 км зайд, нийтдээ жижиг 63 арлаас бүтэж, Малайзын Жохор мужийн өмнө, Индонезийн Риау арлуудын хойно байрладаг. Газар нутаг нь 707.1 км<sup>2</sup> бөгөөд дэлхийд үлдсэн цөөн тооны хот улсуудын нэг юм.
- Сингапурын хүн ам нь 4.59 сая орчим. Хүн амын дийлэнх хувийг Хятадууд эзэлдэг. Захиргаанд хэрэглэгдэх албан ёсны хэл нь англи хэл.
- Сингапур улсын газар нутаг нь Сингапур арал гэх гол арал, бусад жижиг 62 арлаас бүрдэг. Жижиг арлуудаас Жүрон, Пулон, Пулой Убин, Сентоза арлууд нь арай томоохон нь юм. Эх газар буюу Малайзтай холбогдсон хоёр хуурай замын гарц байдаг. Эдгээр нь хойд зүгтээ Жохор хоттой холбогдсон Жохор-Сингапурын далан зам, баруун зүгтээ Малайз-Сингапурын холбоос нэрт гүүр хоёр болно. Сингапур нь бага нутаг дэвсгэртээ, шигүү суурьшилтайн учир эргийн гүехэн усанд шинээр хөрст газар үүсгэдэг юм. 1960-иад онд 581.5 хавтгай дөрвөлжин километр нутагтай байсан бол өдгөө хэмжээ нь 704 болсон бөгөөд 2030 он гэхэд ахин 100-гаар нэмэгдэнэ гэж таамагладаг.
- Сингапур нь хятад, англи, малай, тамил гэсэн албан ёсны 4 хэлтэй. Англи хэл бол тус улсын тэргүүлэгч хэл ба энэ хэл нь бизнес, засгийн газар, дунд сургуулийн сургалтад хэрэглэгддэг. Сингапурын үндсэн хууль болон бүх хууль нь англи хэлээр бичигдсэн байдаг. Сингапурчуудын 80% нь англи хэлийг эзэмшсэн байдаг. Англи хэлний дараа Хятадын Мандарин хэл, тэгээд Малай, Тамил хэлүүд ордог. Сингапурын англи хэлийн үндэс нь Британийн Англи хэл юм.

# Зах зээлийн тойм

3

- Сингапур нь 2013 оны байдлаар 8,6 сая жуулчныг гадаадад аялуулж, энэ үзүүлэлтээр дэлхийд топ 30, Ази Номхон далайн бүсэд эхний 8-д багтсан байна.
- Мөн Сингапур нь 2014 оны байдлаар 11,8 сая олон улсын жуулчин хүлээн авч, Ази Номхон Далайн бүс нутагтаа 6-р байранд эрэмбэлэгдсэн байна.
- Сингапурын аялал жуулчлалын салбарын шууд орлого 2014 онд 18,8 тэрбум синга доллар буюу Сингапурын ДНБ-ий 4,9% байв. Энэ тоо 2015 оны төгсгөлд 3,7 хувиар өсөх төлөвтэй. 2015-2025 онуудад жилийн 2,4%-ийн өсөлттэйгээр, улмаар 2025 онд ДНБ-ний 4,7 хувийг эзлэх байдлаа хадгалж, 24,7 тэрбум синга долларын орлого олох тооцоог Дэлхийн Аялал Жуулчлалын Зөвлөлөөс гаргажээ.
- Аялал жуулчлалын салбарын нийт орлого 2014 онд 38,5 тэрбум синга доллар буюу Сингапурын ДНБ-ний 10,1 хувь байсан бол 2015 онд 4,7 хувиар өсөх таамаглалтай. Харин 2025 онд ДНБ-ний 10,3 хувьд хүрч, 55,8 тэрбум синга долларт хүрэх төлөвтэй байна.
- Сингапурын аялал жуулчлалын хөрөнгө оруулалт нь 2014 онд 17,5 тэрбум синга доллар байсан нь тус улсын нийт хөрөнгө оруулалтанд 18,1 хувийг эзэлж байсан. Энэ үзүүлэлт 2025 он хүртэлх арван жилийн хугацаанд 34,1 тэрбум синга доллар болж, улсын нийт хөрөнгө оруулалтанд 21,6 хувийг эзлэх тооцоог гаргасан.

# Зах зээлийн тойм

4

Аялал жуулчлалын салбарын шууд орлого	2014 он, Тэрбум ам.доллар
Ази Номхон далайн дундаж	21.7
Дэлхийн дундаж	19.4
Сингапур	14.8

Аялал жуулчлалын салбарын нийт орлого	2014 он, Тэрбум ам.доллар
Ази Номхон далайн дундаж	67.3
Дэлхийн дундаж	58.3
Сингапур	30.4

Аялал жуулчлалын салбарын шууд ажлын байр	2014 он, .000 хүн
Ази Номхон далайн дундаж	2000
Дэлхийн дундаж	827
Сингапур	152.7

Аялал жуулчлалын салбарын нийт ажлын байр	2014 он, .000 хүн
Ази Номхон далайн дундаж	4673.9
Дэлхийн дундаж	2076.6
Сингапур	302.9

(World Travel and Tourism Council - Travel and Tourism, 2015)

# Зах зээлийн тойм


5

- Сингапурт бараг 600-аас илүү тооны аяллын агент-компаниуд бүртгэгдэн идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр агентууд инбаунд болон аутбаунд аялал жуулчлалын өрсөлдөөнийг идэвхжүүлж, чанартай аяллуудыг борлуулдаг болно.
- Сингапур нь дэлхийн бараг 240 хотуудтай холбосон 100 гаруй нислэгүүдтэй тул олон улсын аяллын тээврийн маш өргөн бололцоотой юм.
- Сингапур нь аялал жуулчлалын зорих газрын хувьд дэлхийд дээгүүр (141 орноос 11-д) эрэмбэлэгддэг төдийгүй дэлхийн томоохон үзэсгэлэн, яармагийн арга хэмжээний Азийн төв хотуудын нэг болжээ. Аялал жуулчлалын өрсөлдөх чадварын үзүүлэлтээр Сингапур нь Ази, Номхон далайн бүс нутагт Австрали, Гонг Конгийн дараа гуравт орж байна.

# Зах зээлийн тойм

6


Аялал жуулчлалын салбарын орлого /аяллын төрлөөр/



# Зах зээлийн тойм

7

Аялал жуулчлалын салбарын орлого /гадаад,  
дотоод/





# Зах зээлийн тойм

8

- Аялал жуулчлалын салбарт 2014 онд 152,500 ажлын байр бий болгосон нь Сингапурын нийт хөдөлмөр эрхлэлтийн 4.3 хувийг эзэлсэн байна. 2015 онд энэхүү үзүүлэлт 3.7 хувиар өсөх бөгөөд харин 2025 он гэхэд 180,000 ажлын байрыг шинээр бий болгоно гэж тооцоолж байна.
- 2014 оны байдлаар Сингапурын аялал жуулчлалын салбарт шууд ба шууд бус 303,000 хүн ажиллаж байгаа нь нийт ажиллагсдын 8.5 хувь юм. 2015 онд энэ тоо 2.4 хувиар өсөж, харин 2025 онд 323,000 хүрэх төлөвтэй байна.


# Визийн нөхцөл

9

- 2014 оны байдлаар Сингапурын иргэд дэлхийн 170 улс орнуудад визгүй буюу газар дээр нь виз авах боломжтой нөхцөлөөр гадаадад зорчиж байна. Энэхүү үзүүлэлтээр 2014 онд Сингапурын паспорт дэлхийд 5-д эрэмбэлэгдсэн бол, 2015 онд Arton Capital санхүүгийн фирмээс Дани, Финланд, Япон, Люксембург, Голландын паспортуудтай зэрэгцүүлэн дэлхийд 4-д үнэлсэн байна.
- Монгол улсад 1990 оноос хойш Сингапурын иргэд 14 хоногийн хугацаагаар визгүй зорчих нөхцөлтэй байдаг нь аялал жуулчлалыг хөгжүүлэхэд боломжтой таатай нөхцөл юм.

# Визийн нөхцөл

10



(Wikipedia - Hong Kong Immigration Department, 2014)

# Жуулчдын онцлог

11

- Сингапур нь байгалийн аялал жуулчлалын нөөц хязгаарлагдмал бөгөөд дотоод аялал жуулчлал бараг байхгүй орны нэг тул Сингапурчууд дэлхийн бусад орнуудад байгальд, далайд амрах аялан жуулчлах сонирхол их байдаг.
- 2013 онд Сингапурын 8674066 аялагчид гадаадад аялснаар энэхүү үзүүлэлт нь өмнөх оноос 7,8 хувиар өсжээ. Сингапур нь гадаад аяллаар Азийн топ 10 орны 8-д багтдаг бөгөөд аялалд 7,5 тэрбум ам.доллар зарцуулдаг байна.
- Сингапур нь цөөн хоног буюу 7-14 хоног цалинтай амардаг орнуудын тоонд багтдаг. Мөн нийт 11 удаа нийтээр тэмдэглэх баярын өдрүүдээр цалинтай амардаг болно.
- Хэрэв гэр бүлийн орлого нь 8700 америк доллараас илүү бол Сингапурын жуулчныг чинээлэг жуулчдын бүлэгт багтааж тооцно. Сингапурын жуулчид нь чанартай, үнэ цэнэтэй аяллыг худалдан авах бүрэн чадамжтай байдаг.
- Сингапурын жуулчдын дийлэнх олонх буюу 71 хувь нь бүтэн ажилтай, харин 21 хувь нь менежер, 32 хувь мэргэжлийн ажилтнууд байдаг.

# Жуулчдын онцлог

12

- Сингапурын гадаадад аялсан жуулчид үндсэндээ 34-54 насныхан байдаг байна.
- Дунджаар гадаадад аялсан нийт Сингапур жуулчдын 57 хувь нь эрэгтэй, харин үлдсэн 43 хувь нь эмэгтэйчүүд болно.
- Сингапурчууд дунджаар жилд дөрвөн удаа ажил, амралтын зорилгоор гадаадад аялдаг. Аялал нь дунджаар дөрөв хоног үргэлжилдэг.
- Сингапурчуудын хувьд 11-12 болон 6-р сарууд нь аялал жуулчлалаар явдаг гол сарууд байна.
- Сингапурын жуулчдын хувьд аяллын аюулгүй байдлыг хамгийн гол зүйл гэж үздэг бол, чанартай амралт болон гэр бүлийнхэнд тохиромжтой аяллууд нь мөн чухал хүчин зүйлүүд болно.
- Сингапурын жуулчдын дийлэнх олонх үндсэндээ агаарын тээврийг, үлдсэн нь далайн тээврийн хэрэгслээр аялдаг.

Он	Тээврийн хэрэгслийн төрөл		Нийт зорчигчдын тоо
	Агаарын тээвэр	Далайн тээвэр	
2007	4151229	1872901	6024130
2008	4854604	1973758	6828362
2009	4959767	2000957	6960724
2010	5617110	1725166	7342276
2011	6082620	1670306	7752926
2012	6485268	1562540	8047808
2013	6960428	1686638	8674066

(Yearbook of Statistics Singapore, 2014)

# Жуулчдын онцлог

13

- Агаарын тээврийн Singapore Airlines компанийн нислэгийг Сингапурын жуулчид аялал жуулчлалдаа голлон сонгодог байна.
- Сингапурын аяллаар зорих газраа сонгоход нөлөөлдөг хүчин зүйлүүдээ дараах хүснэгтээр үзүүлэв.

Аяллаа сонгоход гол нөлөөлөх хүчин зүйлүүд	Сонголтын хувь
Аюул, эрсдэлгүй зорих газар нутаг	64
Аяллаар очиход сонирхолтой үзмэр	52
Аяллын үнэ цэнэ нь баталгаатай газар нутаг	47
Маш сайн хоол, ундаатай газар нутаг	35
Нутгийнхний найрсаг, зочломтгой байдал	31
Дэлхийн хэмжээний байгалийн үзэсгэлэнт газар нутаг	28
Гэр бүлийнхнээрээ аялахад тохиромжтой газар нутаг	27
Цэвэрхэн хот тосгон, сайн дэд бүтэц	23
Түүх, соёлын баялаг өв	23
Дэлхийн нэртэй брэнд бүтээгдэхүүнийг худалдан авах боломж	22
Чанартай зочид буудал, байр сууц	18
Баяр ёслол, эвент, их наадмын арга хэмжээ	16
Урлаг, соёлын өв	14
Дамжин өнгөрөхгүй шууд нислэгтэй газрууд	14

(Yearbook of Statistics Singapore, 2014)

# Үйлчилгээний сонголт

14

- Сингапурын жуулчдын үйлчилгээний сонголтын талаар одоогоор иж бүрэн судалгаа байхгүй бөгөөд энэ нь зорих газар бүрт өөр юм.
- 2011 онд АНУ-д аялал жуулчилсан жуулчдын дунд явуулсан судалгаанаас үзэхэд, нийт жуулчдын 57 хувь нь амралтын аяллаар жуулчилсан байна.
- Харин Австралид хийсэн судалгаанаас үзэхэд, нийт аяллаар ирсэн Сингапурчуудын 63 хувь нь амралт, чөлөөт цагийн зорилгоор Австралийг зорьж ирсэн гэж хариулсан байна.
- Жуулчдын 94 хувь нь дэлгүүрт худалдан авалт хийх, 91 хувь ресторанд хооллоход бусад бүх үйлчилгээнүүдээс илүү ач холбогдол өгдөг байна. Мөн жуулчдын тал (50) хувь нь аялал жуулчлалын гол үзмэрүүдийг сонгож үздэг.

# Үйлчилгээний сонголт

15

Үзмэр, үйлчилгээний төрлүүд	Сингапурын жуулчдын сонгосон байдал, %
Шоппинг буюу дэлгүүрт худалдан авалт хийх	94
Ресторанд хооллож, ундлах	91
Хотын үзмэрүүд	50
Түүхэн газруудыг үзэх	39
Чөлөөт цагийн сэдэвчилсэн аяллууд	35
Жижиг хот, тосгоноор аялах	25
Үндэсний паркаар аялах	23
Музей, урлагийн галерейд зочлох	21
Хөтөчтэй аялал	21
Хөдөө, орон нутагт аялах	20
Соёлын өвийн аялал	20



# Зорих газрууд

16

- 2013 оны 12 дугаар сард Мастеркарт байгууллагаас жилд хоёроос доошгүй удаа гадаадад аялдаг 1600 гаруй Сингапурын жуулчдын дунд судалгаа явуулахад тэдний хувьд аяллаар зорьдог гол газар нутаг нь хөрш зэргэлдээ Зүүн өмнөд Ази байсан байна. Үүнийг аяллын үнэ өртөг болон Сингапурчуудын ажил, гэрээсээ алс холдох дургүй байдагтай ч холбон тайлбарлаж болох талтай.
- Нийт гадаадад аялсан Сингапурчуудын 56 хувь нь Зүүн өмнөд Азийн хөрш зэргэлдээ Малайз, Тайланд, Индонез зэрэг улсуудад, 30 хувь нь Гонг Конг, БНХАУ, Австралид, харин үлдсэн 14 хувь нь АНУ зэрэг дэлхийн бусад улсуудад аялжээ.
- Сингапурчуудын аялал жуулчлалын гол зорих газрууд нь 1) Малайз, 2) Тайланд, 3) Индонез улсууд юм. Үүний дараа Гонг Конг, БНХАУ байх бөгөөд арай цөөн тооны аялалтай нь Дэлхийн бусад орнууд, түүний дотроос АНУ, ИБУИНВУ тус тус болно.
- Япон, Өмнөд Солонгос, Австрали, Тайвань, Гонг Конг зэрэг өндөр хөгжилтэй орнуудад аялан жуулчлах нь нийтлэг хүсэл, эрмэлзэл байдаг байна.

# Зорих газрууд

17

- Сингапурын жуулчдын сонирхлыг татаж байгаа аялал жуулчлалаар зорих газруудын талаар Сингапурын оршин суугчдаас авсан судалгааны дүн:

2013 оны байдлаар Сингапурын жуулчдын сонирхлыг хамгийн ихээр татаж байгаа газрууд		Аялал жуулчлалаар зорих топ 10 улсууд	
№	Зорих газрууд	№	Зорих улсууд
1	Мальдив	1	Тайланд
2	Өмнөд Солонгос	2	БНХАУ
3	Чех	3	Индонез
4	Бруней	4	Малайз
5	Тайвань	5	Филиппин
6	Швейцарь	6	Гонг Конг
7	Япон	7	Тайвань
8	Шинэ Зеланд	8	Өмнөд Солонгос
9	Бразил	9	Австрали
10	Арабын Эмират	10	ИБУИНВУ

# МӨНГӨНИЙ зарцуулалт

18

- Сингапурын жуулчны мөнгөн зарцуулалт нь насны бүлгээс хамаарах бөгөөд 18-24 насны залуучууд аялалд дунджаар 1643 Сингапур долларыг зарцуулдаг. Харин 25-ээс дээш насны хүүхэдгүй жуулчин аялалд дунджаар 2241, хүүхэдтэй гэр бүлээрээ аялагчид 3160, ахмадууд 3768 Сингапур долларыг зарцуулдаг байна.
- Ер нь Сингапурчууд “өөрийн олсон орлогын боломжит үлдэгдлийг зөв зүйлд зарцуулах” философиор мөнгөн зарцуулалтаа хийдэг нийтлэг төрхтэй.
- Австралид аялсан Сингапур жуулчин дунджаар 21 хонож, нийт аялалдаа 4144 австрали долларыг, нэг өдөрт 197 австрали долларыг зарцуулсан тооцоо байна.
- Сингапурын жуулчдын хувьд сайн хоол ундаа болон дэлгүүрт наймаа хийхдээ мөнгө зарцуулахыг чухалчилдаг.

# Маркетингийн сувгууд

19

- Google Traveler Report судалгаанаас үзэхэд, амралтаараа аялах жуулчдын бараг 70 хувь нь интернетийн мэдээллийг үнэн, зөв мэдээллийн эх үүсвэр гэж үздэг болсон байна. Мөн бараг 64 орчим хувь нь аяллын мэдээллээ онлайнгаар хайх нь зүйтэй гэж итгэдэг.
- Дэлхий нийтээр онлайн технологийг өргөнөөр нэвтрүүлж ашигладаг болсон энэ үед Сингапурчуудын дийлэнх олонх нь (70-аас илүү хувь нь) аяллын сонголтоо интернетийн эх үүсвэрээс авсан мэдээллээр хийдэг байна. Мөн Сингапурт байрладаг аяллын агентуудаар дамжуулан сонголт хийх нь багагүй хувьтай байдаг.
- Аяллын мэдээлэл авах болон сонголт хийхдээ CTC Holidays, Chan Brothers, SA Tour гэсэн Сингапурын томоохон аяллын гурван компаниар дамжуулан гүйцэтгэхийг Сингапурчуудын дийлэнх олонх зөв гэж үздэг.
- Судалгаанаас үзэхэд, Сингапур жуулчдын аяллын сонголтоо хийхэд нөлөөлдөг гол хүчин зүйлүүдийн гол нь аяллын үнэ өртөг, чанартай холбоотой байдаг байна.

Эзлэх байр буюу эрэмблэл	Аяллын шийдвэр гаргахад нөлөөлөх хүчин зүйлүүд
1	Аяллын үнэ өртөг ба чанар /value for money/
2	Аяллын агент буюу түр операторын нэр хүнд
3	Аяллаар үзэх зүйл, үзмэрүүдийн байдал
4	Багц аяллын хямдрал
5	Аяллын бусад урамшуулал, хямдралууд
6	Тухайн жуулчны хувийн сэтгэгдэл, дурсамж
7	ТВ, мэдээллийн сурталчилгаа
8	Байр сууц, тээвэр, хоол ундааны чанар
9	Сонин дээр гарсан сурталчилгаа
10	Аяллын ажилтнуудаас үзүүлэх үйлчилгээ
11	Бусдын ам дамжсан яриа
12	Сэтгүүлийн сурталчилгаа

# Маркетингийн сүвгүүд

20

Сингапурын жуулчдын аялын мэдээллийн эх сурвалжууд	Хувь
Интернетийн эх сурвалжийг компьютер ашиглах	45
Агаарын тээвэрлэгч компаниас шууд	36
Аялал жуулчлалын компаниас шууд	36
Найз нөхөд, хамаатан саднаас	19

- Сингапурын жуулчдын бараг тал хувь нь компьютер ашиглан интернетээс аялал жуулчлалын мэдээлэл авдаг бөгөөд жуулчдын гуравны нэг илүү хувь нь агаарын тээвэрлэгч компани, мөн гуравны нэг илүү хувь нь аяллын компаниас холбогдох мэдээллээ авдаг байна.

# Сингапурын аялал жуулчлалын өрсөлдөх чадвар

21

Үзүүлэлтүүд	Эзлэх байр, дэлхийн 141 орноос	Оноо
<b>Аялал жуулчлалын өрсөлдөх чадварын индекс</b>	<b>11</b>	<b>4.86</b>
<b>Орчны үнэлгээ</b>	<b>5</b>	<b>5.89</b>
Бизнесийн орчин	1	6.13
Аюулгүй байдал	8	6.40
Эрүүл мэнд, ариун цэвэр	61	5.44
Хүний нөөц, ажиллах хүчний зах зээл	3	5.49
Мэдээлэл, технологийн боловсрол	10	5.98
<b>Аялал жуулчлалын бодлого, орчны нөхцөл</b>	<b>1</b>	<b>4.83</b>
Аялал жуулчлалын тэргүүлэх байдал	4	5.95
Олон улсад нээлттэй байдал	1	5.25
Үнийн өрсөлдөх чадвар	116	3.82
Тогтвортой байдал	51	4.31
<b>Дэд бүтэц</b>	<b>5</b>	<b>5.63</b>
Агаарын тээвэр	6	5.26
Газрын ба далайн тээвэр	2	6.44
Аялал жуулчлалын үйлчилгээний дэд бүтэц	34	5.17
<b>Байгаль, соёлын нөөц</b>	<b>40</b>	<b>3.08</b>
Байгалийн нөөц	69	2.87
Соёлын ба бизнес аяллын нөөц	22	3.30

# Өрсөлдөгчид

22

- **Малайз (Malaysia)**

2015 оны дэлхийн аялал жуулчлалын өрсөлдөх чадварын үзүүлэлтээр Малайз нь дэлхийд 25-р байранд Ази, Номхон далайн бүс нутагтаа 7-р байранд эрэмблэгдсэн байна.

Малайз нь байгалийн болон түүх, соёлын өвөрмөц онцлогоороо олон улсын жуулчдыг татдаг Зүүн Өмнөд Азийн улс билээ. Газарзүйн хувьд хил залгаа байдаг тул Сингапурын жуулчид ирж, очиход хялбар байдаг. Малайз нь аялал жуулчлалын олон улсын зах зээлд хэд хэдэн сонирхолтой кампанит ажлууд (Visit Malaysia Year, Malaysia-Truly Asia) зохиож, жил бүр ирдэг жуулчдын тоо нэмэгдсээр байна. Сингапурын жуулчид тооны хувьд Малайзд ирэх нийт олон улсын жуулчдын дунд эхний байранд ордог бөгөөд бараг 60 гаруй хувийг эзэлдэг байна. 2014 онд Сингапураас бараг 14 сая жуулчид аялан ирсэн нь нийт жуулчдын бараг 52 хувийг бүрдүүлж байгаа тасархай үзүүлэлт юм. Гэхдээ Сингапурын жуулчдын нилээд хувь нь нэг өдрийн аялагчид байдаг болохыг статистикийн шинжилгээнд тэмдэглэсэн байдаг. Малайз нь хэл, соёл адилхан бөгөөд тусгайлан хийх аяллууд, үзмэрүүд болон тээврийн хувьд сайн холбогдсон тул Сингапурын жуулчдын аялах хамгийн топ өрсөлдөгч байх болно.



# Өрсөлдөгчид

23

- **Индонез (Indonesia)**

2015 оны дэлхийн аялал жуулчлалын өрсөлдөх чадварын үзүүлэлтээр Индонез нь дэлхийд 50-р байранд Ази, Номхон далайн бүс нутагтаа 11-р байранд эрэмблэгдсэн байна. Индонез нь хүн амын тоо, газар нутгийн хэмжээгээрээ Зүүн Өмнөд Азид томд тооцогдох бөгөөд аялал жуулчлалын хүчин чадал, бололцоо жилээс жилд нэмэгдсээр байгаа юм. 2014 оны байдлаар Индонез улсад жилдээ 9 сая гаруй жуулчин аялсан бөгөөд жуулчдын гуравны нэг нь Балид жуулчилсан байна. Индонезид жил бүр 1,5 сая илүү жуулчин Сингапураас аялан ирдэг бөгөөд энэхүү үзүүлэлтээр гаднаас ирсэн аялагч улсыг тогтмол тэргүүлж байна. Сингапурын жуулчдын хувьд Индонез нь аялан очиход хялбар, ойрхон бөгөөд байгалийн үзэсгэлэнтэй байдал, жуулчдын үйлчилгээгээр аяллын топ газруудын нэг хэвээр байх болно.





# Өрсөлдөгчид

24

- **Тайланд (Thailand)**

2015 оны дэлхийн аялал жуулчлалын өрсөлдөх чадварын үзүүлэлтээр Тайланд нь дэлхийд 35-р байранд Ази, Номхон далайн бүс нутагтаа 10-р байранд эрэмблэгдсэн байна.

ДНБ-д бараг 9-10 хувийг эзэлдэг аялал жуулчлалын салбар бол Тайландын эдийн засагт маш чухал нөлөө бүхий салбар билээ. Тайланд нь аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үзмэр, үйлчилгээний төрөлжилт, онцлогоороо дэлхийн өнцөг булан бүрийн жуулчдын сонирхлыг татдаг. 2013 оны байдлаар Тайландад жилд 23 сая жуулчин аялан ирж байгаа бөгөөд үүний дотор Сингапурын жуулчид нь эхний 9-д багтдаг. 2014 онд гэхэд Сингапураас 844 мянган жуулчид Тайландад аялсан байна.



# Өрсөлдөгчид

25

- **Гонг Конг (Hong Kong)**

2015 оны дэлхийн аялал жуулчлалын өрсөлдөх чадварын үзүүлэлтээр Гонг Конг нь дэлхийд 13-р байранд Ази, Номхон далайн бүс нутагтаа 4-р байранд эрэмблэгдсэн байна. Гонг Конг жилдээ 36 саяас дээш жуулчин хүлээн авдаг Азийн төдийгүй дэлхий топ аялал жуулчлалын хот юм. 2013 оны байдлаар Сингапураас 522 мянга гаруй жуулчид Гонг Конгд аялсан нь нийт ирсэн жуулчдын 2%-ийг эзэлж, жуулчин ирүүлсэн топ улсуудын жагсаалтын 7-рт бичигдсэн байна. Гонг Конгийн эдийн засаг-тээврийн хөгжил, амралт зугаа цэнгэлийн үзвэр, үйлчилгээ болон өндөр чанарыг эрхэмлэдэг нь олон улсын жуулчдыг, Сингапурын жуулчдыг татах Азийн хүчтэй өрсөлдөгч газар нутаг байх нөхцөлийг бүрдүүлж байна.



# Өрсөлдөгчид

26

- **БНХАУ (China)**

2015 оны дэлхийн аялал жуулчлалын өрсөлдөх чадварын үзүүлэлтээр БНХАУ нь дэлхийд 17-р байранд Ази, Номхон далайн бүс нутагтаа 6-р байранд эрэмблэгдсэн байна. Жилдээ 60 гаруй сая жуулчин хүлээн авдаг БНХАУ нь аялал жуулчлалын хүлээн авах чадамж, үзмэрүүд болон аялал жуулчлалын эдийн засгийн бусад олон үзүүлэлтээр бүс нутагтаа тэргүүлж, дэлхийн аялал жуулчлалын чиг хандлага, жуулчны урсгалыг тодорхойлогч улс болсон билээ. Сингапурын жуулчдын хувьд Хятад улсаар хийх аяллууд нь сонирхолтой хэвээр бөгөөд Хятадын аялал жуулчлалын компаниуд ч Сингапурын зах зээлд чармайн ажиллаж байгаа юм.



# Өрсөлдөгчид

27

- **Тайвань (Taiwan)**

2015 оны дэлхийн аялал жуулчлалын өрсөлдөх чадварын үзүүлэлтээр Тайвань нь дэлхийд 32-р байранд Ази, Номхон далайн бүс нутагтаа 9-р байранд эрэмблэгдсэн байна. 2013 оны байдлаар Тайвань нь жилдээ 8 сая гаруй олон улсын жуулчид хүлээн авдаг бөгөөд Сингапураас ирэх жуулчдын тоо 370 мянга орчим юм. Тайваньд ажил төрөл, бизнесийн болон амралт, зугаа цэнгэлийн аяллын бүхий л төрлүүд сайн хөгжсөн байдаг.



# Өрсөлдөгчид

28

- Япон (Japan)

2015 оны дэлхийн аялал жуулчлалын өрсөлдөх чадварын үзүүлэлтээр Япон нь дэлхийд 9-р байранд Ази, Номхон далайн бүс нутагтаа Австралийн дараа 2-р байранд эрэмблэгдсэн байна. 2014 оны байдлаар жилдээ 13,4 сая гаруй жуулчин хүлээн авдаг Япон улсад 227 мянга гаруй Сингапурын жуулчид аялсан нь дээрээсээ 9 дахь байранд жагсаагдсан байна. Эдийн засаг, технологийн өндөр хөгжил, Дэлхий соёлын өвүүд болон жуулчдад зориулсан олон гайхамшигтай үзмэр, үйлчилгээ бүхий Япон улс нь Сингапурын жуулчдын аялах дуртай газруудын нэг юм.



# Өрсөлдөгчид

29

- **БНСУ (South Korea)**

2015 оны дэлхийн аялал жуулчлалын өрсөлдөх чадварын үзүүлэлтээр БНСУ нь дэлхийд 29-р байранд Ази, Номхон далайн бүс нутагтаа 8-р байранд эрэмблэгдсэн байна. Жилдээ 11 сая гаруй гадаадын жуулчид хүлээн авдаг БНСУ нь Сингапурын жуулчдын хувьд шинэ газар нутаг боловч аяллаар зорих жуулчдын тоо нэмэгдсээр байгаа юм.



# Өрсөлдөгчид

30

- **Филиппин (Philippines)**

2015 оны дэлхийн аялал жуулчлалын өрсөлдөх чадварын үзүүлэлтээр Филиппин нь дэлхийд 74-р байранд Ази, Номхон далайн бүс нутагтаа 14-р байранд эрэмблэгдсэн байна. 2014 оны байдлаар жилдээ 4,8 сая жуулчин Филиппин улсад 138 мянга гаруй Сингапурын жуулчид аялжээ. Филиппиний аялал жуулчлалын компаниуд шинэ аялал, бүтээгдэхүүн, үйлчилгээ хөгжүүлэн Сингапурын зах зээлд идэвхтэй ажиллаж байна.



# Өрсөлдөгчид

31

- **Австрали (Australia)**

2015 оны дэлхийн аялал жуулчлалын өрсөлдөх чадварын үзүүлэлтээр Австрали нь дэлхийд 7-р байранд Ази, Номхон далайн бүс нутагтаа 1-р байранд эрэмбэлэгдсэн байна. Нэг жилд 6 саяас илүү жуулчин хүлээн авдаг Австралийн хувьд Сингапурын жуулчин нь хамгийн таатай жуулчны тоонд зүй ёсоор ордог байна. Одоогоор Сингапураас жилдээ 320 гаруй мянган жуулчин Австралид аялж байгаа ч Австралийн аялал жуулчлалын компаниудын шинэ бүтээгдэхүүн, аяллын чанар, аюулгүй байдал зэрэг олон үзүүлэлтээр энэ тоо цаашид түргэн өсөх магадлалтай юм.





# Өрсөлдөгчид

32

- **Шинэ Зеланд (New Zealand)**

2015 оны дэлхийн аялал жуулчлалын өрсөлдөх чадварын үзүүлэлтээр Шинэ Зеланд нь дэлхийд 16-р байранд Ази, Номхон далайн бүс нутагтаа 5-р байранд эрэмбэлэгдсэн байна. 2013 оны байдлаар 3 сая гаруй Шинэ Зеландад аялсны дотор Сингапурын 40 гаруй мянган жуулчид багтаж байна.



## Сингапурын жуулчдыг шинээр хүлээн авч байгаа улс, орнуудад гарч байгаа нийтлэг хүндрэлтэй асуудлууд

33

- Жуулчны тээврийн хязгаарлалт. Сингапурыг тухайн улстай холбосон нислэг, зорчигч тээврийн бусад хүндрэлүүд нь Сингапурын жуулчдыг өөр шууд, хялбар нислэгтэй улс орнууд руу аялахад хүргэж байна. Иймд Монгол улсын хувьд аялал жуулчлалын таатай бөгөөд шинэ зах зээл болох Сингапурын жуулчдыг нэмэгдүүлэхийн тулд чартер нислэгийг нэмэгдүүлэх замаар Улаанбаатар-Сингапурын шууд нислэгийг бий болгох шаардлагатай.
- Аяллын үнийн өрсөлдөөн. Сингапурын жуулчдыг татахын тулд уламжлалт хүчтэй өрсөлдөгч улсуудаас гадна Филиппин зэрэг олон орнууд хямдавтар боловч сонирхолтой аяллуудыг тусгайлан бий болгож ажиллаж байна.
- Сингапур нь өөрөө хязгаарлагдмал байгалийн нөөц баялагтай улс тул жуулчид тухайн аялах газрын орон нутгийн байгаль хамгаалал, тогтвортой хөгжлийн байдалд илүү ач холбогдол өгч байна.

# ЗӨВЛӨМЖ

- Сингапурт аялах жуулчдын тоо нэмэгдэж, дэлхийн аяллын топ хот болохын зэрэгцээ гадаадад аялах Сингапур жуулчдын тоо жилээс жилд нэмэгдэж байна. Одоогоор Монголд аялсан Сингапур жуулчдын тоо 2012 оны байдлаар нэг мянга гаруйхан байгаа нь чамлалттай үзүүлэлт юм.
- Сингапурчуудын ажил, амралтын онцлог болон аяллын үнэ, өртөгт анхаарах байдлаас шалтгаалж аяллын гол бүс нь Зүүн Өмнөд Азийн хөрш зэргэлдээ Малайз, Тайланд, Индонез улсууд байгаа боловч алс холын шинэ газар нутгуудад аялах хандлага өсөж байгаа.
- Сингапурын залуу үеийнхэн шинэ, онцгой дурсамжтай аяллыг илүүд сонирхож байгаа тул зөвхөн уг зах зээлд зориулсан нийтлэг бүс аяллын багцыг бий болгож, сурталчлах нь амжилтанд хүрэх магадлалтай юм.
- Сингапур жуулчид нь интернет, онлайнаар зорих газрын тухай, үзмэр, үйлчилгээний талаарх мэдээллийг олж энэ нь аяллын шийдвэр гаргахад шууд нөлөөлж байгаа тул Монголын тур операторуудын хувьд веб хуудас, интернет мэдээллээ Сингапурын жуулчдад зориулсан бүтээгдэхүүн, үйлчилгээгээр баяжуулах нь чухал байна.
- Сингапурын тур оператортай хамтран ажиллах нь тусгайлсан аяллуудыг бий болгож, үйлчилгээг сайжруулах замаар Сингапурын жуулчдыг Монголд татах хамгийн оновчтой арга юм. Иймд Сингапур, Монголын аялал жуулчлалын байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах болон тур операторуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх шаардлагатай.
- Сингапурын хэвлэл мэдээллээр Монголын сурталчилгааг нэмэгдүүлэх, Монголд аялсан жуулчны сэтгэгдлийг хэвлүүлэх болон Сингапурын сэтгүүлчдийн тусгай бүлгийг урьж Монголд аялуулах нь чухал байна. Сингапурт Монголын аялал жуулчлалын тухай үнэн зөв мэдээлэл хангалтгүй бөгөөд зорилтот бүлэгт хүрч чадахгүй байгаа юм.
- Аялал жуулчлалын төрөлжсөн үзэсгэлэн яармаг болох ITB Asia нь Сингапур улсад тогтмол зохион байгуулагдаж эхэлснээс хойш есөн жил гаруй болжээ. Уг үзэсгэлэн нь B2B төдийгүй Сингапурын оршин суугчдад аяллын мэдээлэл, сурталчилгаа хүргэх чухал үүрэгтэй тул цаашид Монголын тур операторууд зохион байгуулалттайгаар уг үзэсгэлэн-яармагт оролцож ажиллах шаардлагатай. 2015 оны **ITB-Asia** үзэсгэлэн 10 сарын 21-25 хооронд уламжлал ёсоор Сингапурын Marina Bay Sands-д болно.